

ФИБО ГЛОБАЛ ХХК
МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО

1. “Фибо Глобал” ХХК нь Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа удирдан чиглүүлэх зорилгоор дараах мэдээллийн аюулгүй байдлын бодлогыг батлав.
 - 1.1. Монгол залуусын оюунаар бүтсэн орчин үеийн технологийн шийдлийг дотоодын болон гадаадын зах зээлд түгээж, байгальд ээлтэй, ашиглахад хялбар бүтээгдэхүүн үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэж, үнэ цэнэ бүтээхэд орших ба үйл ажиллагаандаа боловсруулагдаж байгаа бүх төрлийн өгөгдөл мэдээлэл дамжуулах, хадгалахтай холбоотой мэдээллийн үүлэн технологийн болон дэд бүтцийг хамгаалах, гадаад, дотоод санаатай болон санамсаргүй үйлдэгдэх бүх төрлийн эрсдэл, аюул заналаас компанийн мэдээлэл, мэдээллийн хөрөнгийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжтэй байдлыг хамгаалахын тулд бизнесийн стратеги зорилтуудтай уялдуулан Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэн тогтмол сайжруулан ажиллана.
2. МАБ-ын бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд дараах үндсэн зорилтуудыг дэвшүүлэн ажиллана. Үүнд:
 - 2.1. ISO/IEC 27001:2022 стандартыг үндэслэн компанийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээнд мэдээллийг аюулгүй байдлын соёлыг бий болгоно.
 - 2.2. Компани нь хэрэглэгч болон хамтрагч байгууллагууд, гуравдагч түншүүдтэй хамтран ажиллахдаа мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн болон хүртээмжтэй байдлыг хангаж ажиллана. Мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангуулахад ажилтнуудын үүрэг оролцоо, хариуцлагыг тодорхойлон хэрэгжилтийг хэвшүүлнэ.
 - 2.3. Хэрэглэгч, хамтрагч байгууллагын итгэлийг хүлээж, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхийн тулд бүтээгдэхүүн үйлчилгээ, систем, дэд бүтцийн хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангаж ажиллахыг зорино.
 - 2.4. Мэдээлэл, нууц мэдээлэл, өгөгдөл, оюуны өмч, хувь хүнийг тодорхойлох боломжит өгөгдөл зэрэг бүх өгөгдөл болон мэдээлэл нь үнэт хөрөнгө бөгөөд эрхгүй этгээд хандах, хуваалцах, ил болгох, өөрчлөх, алдах, гэмтээх, устгахаас хамгаална.
 - 2.5. Мэдээлэл түүнийг хадгалах, дамжуулах, ашиглах явцдаа мэдээлэл дамжин өнгөрөх сүлжээ, компьютерын систем, программ хангамжийг буруугаар ашиглахаас сэргийлж, мэдээллийг аюулгүй байдлын зөрчлөөс үүсэх хохирлоос урьдчилан сэргийлэх, илрүүлэх.
 - 2.6. Мэдээллийн аюулгүй байдлын бодлого, журмуудыг тогтмол хугацаанд хэлэлцэж шаардлагатай тохиолдолд тухай бүр өөрчлөлт оруулан хянан шинэчлэн сайжруулна.Хууль, эрх зүйн шаардлагууд, гэрээнд тусгасан аюулгүй байдлын заалтуудыг мөрдөх,
 - 2.7. Мэдээлэл болон мэдээллийн систем, компанийн компьютер технологийн сүлжээ нь компанийн бусад биет эд хөрөнгийн нэгэн адил компанийн өмч бөгөөд хамгаалагдаж бүртгэгдсэн байна. Эдгээр нь нууцын зэрэглэлээр ангилагдах бөгөөд эрх олгогдоогүй этгээдэд хаалттай, хандах боломжгүй байна.